

БЭЭЖИНГИЙН ОДОН ОРНЫ ЭРТНИЙ ТӨВ /Гугуань Сянтай/

Ц.БАТБАЯР*

Бээжин хотын хуучин хэрмийн зүүн урд өнцөгт орших 18 метр өндөр, 24 метр урт, 20 метр өргөн цамхаг, түүнийг тойрсон барилгууд нь Мин улсын үед 1422 онд баригдсан Бээжин хотын одон орны эртний төв болно. Түүний эх түүхийг сөхөн үзвээс Хубилай хаан 1279 онд Юань гүрнийг байгуулсны дараа Одон орны төв байгуулах зарлиг буулгасны дагуу одоогийн байрлаж буй газрын эсрэг Чанань өргөн чөлөөний нөгөө талд Одон орны төвийг анх байгуулжээ. Түүхэн явцад тэрхүү Юань гүрний үеийн төв үгүй болж сүүлд 1422 онд байгуулсан төв үлдэж хоцорчээ. Хэдий тийм ч Юань гүрний үед анх хийсэн одон орны хэд хэдэн багаж хэрэгслийг сүүлд Мин, Чин улсын үед улам боловсронгуй болгон хүрлээр цутгасан нь одоо энэ төвд хадгалагдаж байна.¹ Монгол Улсын Ерөнхийлөгч Н. Энхбаяр 2005 оны 12 дугаар сард БНХАУ-д албан ёсны айлчлал хийх үеэр уг Одон орны төвийг үзэж сонирхсон билээ.

Хубилай хаан лалын мөргөлт Арабын орнуудын тэнгэрийн зурхайч нар Юань гүрэнд ирж цаг улирлын тооны бичиг (хуанли) зохиох, одон орны оргилд ажиллаж одон мичидийн хөдлөл, тэнгэрийн байдлыг ажигж, зурхайн ёс, мэрэг төлгийн талаар хаанд санамж өгч байх явдлыг хөхиүлэн дэмжиж байжээ. Одон орны оргил Юань улсын үед эзэн хааны шууд мэдэлд байжээ. Хааны зурхайчид нар, сарны хиртэлтийг ажиглаж тооцох, жил бүрийн цаг тооны бичгийг зохиож өвлийн тэргүүн сарын нэгэнд хаанд өргөн барьж байх үүрэгтэй байв. Эзэн хаан “Тэнгэрийн хөвүүн” учраас нар сарны хиртэлтийг эс мэдвээс тэнгэрт үл таашаагдах, хааны “аз харина” гэсэн үг байв. Түүнчлэн

эзэн хааны өргөл барьц өргөх, мөргөл үйлдэх, аян дайнд мордох, орон нутгаар хийх аялал зэрэг үйл явдал нь цаг тооны бичигт тэмдэглэгдсэн ивээлтэй сайн өдөр тохиох ёстой байв.

Юань гүрний хятад одон орончид дотроос нэрд гарсан нь зурхайч, усан сувгийн зохион бүтээгч Го Шоужин байв. Тэрээр Юань гүрний үед Даду хотын усан сувгийн системийг тогтоосноор нэрд гарчээ. Түүний зохион бүтээсэн одон орны багаж хэрэгслүүд Одон орны төвд хүндтэй байрыг эзэлжээ.² Юань гүрний үед хятадын болон арабын орнуудын одон орончид, зурхайчдыг аль алийг нь хөхиүлэн дэмжиж, од гаригийн хөдөлгөөнийг ажиглан тааж мэдэх талаар “уралдуулж” өрсөлдүүлж байжээ. Тийм замаар чухам ямар сургууль, зурхайчдын зурлага үнэнд ойр, бодитойг шалгаруулж байсан бололтой.

Бээжингийн Одон орны төв нь үзэсгэлэнгийн гурван танхим болон цамхаг дээр байрлуулсан 8 ширхэг багаж, түүнчлэн цамхагийн урд талд тавьсан нарны сүүдрээр өвөл, зуны улирлын өдрийн урт богиныг хэмжих багаж зэрэг нийт 3 хэсгээс бүрджээ. Чин улсын үед хааны зурхайчид од гаригийн хөдөлгөөнийг ажигж Манжийн эзэн хаанд илтгэх үүрэгтэй байжээ. Өвөр Монголын түүхч Ваанчиг диссертацидаа бичсэнээр “Дүрс шошго ба Хараан шинээ хэмээх хоёр зүйлийн сүүдэр хэмжих төхөөрөмжийг бүтээснээр одон гариг, нарны сүүдрийг нарийвчлалтай хэмжиж чадсан байна. Дүрс шошго бол жижиг нүхээр гэрэл тусгавал дүрс үүсгэх гэрлийн ухааны аргыг ашиглан үйлдсэн төхөөрөмж байж, түүний

*Ц. Батбаяр- Түүхийн шинжлэх ухааны доктор

¹ <http://www.icm2002.org.cn/K/Observatory.htm>

² Юаньчао, Вэнмин Тансо цуврал номын Юан улсын танилцуулга, Бээжин, Дасян хэвлэлийн газар, 2005, 186-191-р тал.

хэмжилтийн оновчтой нарийвчлалын хэмжээ 2 мм-т хүргэж чаджээ” гэж бичсэн байна.

1900 онд Өрнөдийн 8 гүрний цэргүүд Бээжинг эзлэх үед Франц, Герман одон орны зарим багаж хэрэгслийг олзлон авч явсан боловч Хятадын талын шаардлагаар дэлхийн 1 дүгээр дайны дараа эргүүлэн өгсөн байна. 1956 онд уг төвийг Музей болгон олон нийтэд нээжээ. Олон зуун жилийн борооны

усанд идэгдсэн цамхгийн нэг хэсэг 1979 онд нурж, түүнийг 1983 онд одоогийн байдлаар сэргээн босгосон байна. Өнөөдөр уг музей Юань, Мин, Чин улсын үеийн одон орны судлалын ололтуудыг харуулсан дэлхийд ховор төв болж олон орны төрийн тэргүүн, нэрт эрдэмтдийн сонирхон үздэг газар болсон ажээ.